



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/413

Булган сум

Үерийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх  
ажлын хэсэг байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 7 дугаар зүйлийн 7.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Монгол Улсын засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоол, аймгийн гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн үерийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг гүйцэтгэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийх удирдамжийг 2 дугаар, гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний сургалтын хөтөлбөрийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Үерийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж, боловсруулан тайланг аймгийн Онцгой комисст танилцуулахыг ажлын хэсэгт даалгасугай.

3. Орон нутгийн үерийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг гаргаж, тайланг хугацаанд ирүүлэхийг сумдын Засаг дарга, Гамшгаас хамгаалах орон нутгийн албадын дарга нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга (Хурандаа Ш.Баасандорж) –д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ




Аймгийн Засаг даргын 2023 оны  
05 дугаар сарын 29-ны өдрийн 01/2023 дугаар  
захирамжийн 1 дүгээр хавсралт



ҮЕРИЙН ЭРСДЭЛИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭГ ХИЙХ  
АЖЛЫГ ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн ахлагч: Х.Чинзориг (Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, хошууч)
- Ажлын хэсгийн гишүүд: Г.Гантулга (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн)
- И.Гансүвд (Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн ус судлалын инженер)
- А.Нарантуяа (Статистикийн хэлтсийн мэргэжилтэн)
- Ч.Батдэлгэр (Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэргэжилтэн)
- Г.Батцагаан (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)
- Нарийн бичгийн дарга: Л.Баярмаа (Онцгой байдлын газрын Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, дэслэгч)

Аймгийн Засаг даргын 2023 оны  
05 дугаар сарын 24-ны өдрийн 24/05 дугаар  
захирамжийн 2 дугаар хавсралт



## БУЛГАН АЙМГИЙН ҮЕРИЙН ЭРСДЭЛИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ ХИЙХ УДИРДАМЖ

### **Нэг. Үерийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний зорилго**

Гамшгаас хамгаалах тухай хууль, Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн 2023 оны төлөвлөгөө, Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан "Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам"-ыг хэрэгжүүлэн Булган аймгийн хэмжээнд учирч болзошгүй үерийн аюулыг урьдчилан үнэлж, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөн гамшгийн эрсдэлийг бууруулахад оршино.

### **Хоёр. Үерийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний зорилт**

1. Булган аймгийн хэмжээнд учирч болох үерийн эрсдэлийг урьдчилан тооцоолох, хохирол багатай даван туулах чадавхыг нэмэгдүүлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах.
2. Аюул, эмзэг байдал, өртөнгө, чадавхын эрсдэлийн түвшнийг тодорхойлон бууруулах арга зүйн зөвлөмжийг боловсруулах.

### **Гурав. Хугацаа**

Үерийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулна.

### **Дөрөв. Зохион байгуулалт**

1. Аймгийн Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн нар тойм судалгааг удирдан зохион байгуулна.
2. Ерөнхий үнэлгээ хийх ажлын хэсэг харилцан мэдээлэл солилцох, ярилцлага, дүн шинжилгээ хийж эрсдэлийн үнэлгээний аргачлалаар зохион байгуулна.
3. Ерөнхий үнэлгээнд оролцох алба хаагчдын нэрсийг урьдчилсан байдлаар Онцгой байдлын газрын гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, дэслэгч Л.Баярмаад утсаар /99126072/ болон цахим хаягаар /l.bayarmaa.bul@nema.gov.mn/ хүргүүлнэ.
4. Үнэлгээ хийх ажлын хэсэг үерийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний тайлангаа Аймгийн Онцгой комиссын даргад танилцуулна.



05 дугаар сарын 23-ны өдрийн 143 дугаар захирамжийн 3 дугаар хавсралт



**ҮЕРИЙН ЭРСДЭЛИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ ХИЙХ ХӨТӨЛБӨР**

Хугацаа		Үйл ажиллагаа, сэдэв	Хариуцах алба хаагч
1	2	3	3
		<b>2023 оны 05 дугаар сарын 24-ний өдөр</b>	
09:00	9:10	Бүртгэл	Ажлын хэсэг
09:10	09:30	Эрсдэлийн үнэлгээний эрх зүйн орчин, журам, заавар	Онцгой байдлын газар
9:30	09:50	Үерийн эрсдэлийн үнэлгээний аргачлал танилцуулга	Онцгой байдлын газар
09:50	16:00	Үнэлгээний үе шат	Ажлын хэсэг
16:00	16:20	Үнэлгээний үр дүн	Ажлын хэсэг
16:20	16:50	Тайлан боловсруулах	Аужлын хэсэг
16:50	17:00	Үйл ажиллагааг дүгнэх	Онцгой байдлын газар